



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах ”

**Аудит хийсэн
үндэслэл,
бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108, “Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2025 оны А/44 дүгээр тушаалыг тус тус үндэслэн аудитыг хийж гүйцэтгэв.

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: “БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА”

**Аудитын
тайланг
хүргүүлсэн:**

Аймгийн сонгуулийн хороонд хүргүүлсэн.

Дархан-Уул аймаг

2025 оны 7 дугаар сар

**Аудитын
зорилт**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан аудитын тайланг ҮАГ болон аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлж, бусад байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- *Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахад улсын төсвийн санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;*
- *Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвийн санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;*

**Аудитын
хамарсан
хүрээ**

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороо, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудыг хамруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр удирдаж, аудитын менежер У.Батсүрэн үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Санжаажав нар гүйцэтгэсэн.

**Аудит хийхэд
гарсан
хүндрэл
бэрхшээл**

Аудитад хүндрэл бэрхшээл гараагүй болно.

1.1. НЭГ. СЕХ-НООС ӨГСӨН ЧИГЛЭЛ, ТАЙЛБАРЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА

1.1.1. Сонгууль зохион байгуулах зардлын төсвийг журамд заасны дагуу эдийн засгийн ангилал бүрээр төлөвлөжээ.

Дархан-Уул аймагт орон нутгийн 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах зардалд СЕХ-ны даргын 2025 оны А/18 дугаар тушаалаар 76.4 сая төгрөгийн төсөв баталсныг 3 удаагийн санхүүжилтээр бүрэн олгожээ.

СЕХ-оос төсвийг тооцохдоо сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум болон хэсгийн хорооны тоо зэрэг мэдээллийг үндэслэн 76.4 сая төгрөгөөр төлөвлөж, баталсан байна.

1.1.2 СЕХ-ноос өгсөн тайлбар, чиглэлийг баримтлан ажилласан байна.

Аймаг, сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Дархан-Уул аймгийн сонгуулийн хороонд 14 төрлийн зардалд 76.4 сая төгрөг баталж, санхүүжүүлснээс 38.6 хувь буюу 29.5 сая төгрөгийг аймагт, 61.4 хувь буюу 46.9 сая төгрөгийг Шарын гол сумын сонгуулийн хороонд тус тус хуваарилжээ. Төсвийг СЕХ-ноос өгсөн чиглэл, тайлбарыг баримтлан ажилласан эсэхийг давтан тооцоолоход алдаа зөрчил илрээгүй болно.

1.1.3. Аймгийн Цагдаагийн газарт сонгуулийн хамгаалалттай холбоотой санхүүжилт олгогдоогүй байна

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/82 тоот тушаалын 7 дугаар хавсралтаар орон нутагт хуваарилах зардлын төсвийг баталжээ.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс сонгуулийн зардлын төсвийн төслийн тооцооллыг дээд шатны байгууллагад хүргүүлээгүй бөгөөд УБЕГ-аас сонгогчийн бүртгэлийн тулган шалгах, бүртгэх, таньж оруулах, техник хэрэгсэл, программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах болон бусад зардлын тооцоонд 5.1 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна.

Хүснэгт №2: Улсын бүртгэлийн хэлтэст олгосон санхүүжилт

№	Мөнгөн урамшуулал	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх бичиг хэргийн болон бусад зардал	Техник хэрэгсэл тээвэрлэх турших болон шуурхай багийн зардал	Нийт зардал
1	3,375.0	1,600.0	160.0	5,135.0

Харин аймгийн Цагдаагийн газарт сонгуулийн хамгаалалттай холбоотой санхүүжилт олгогдоогүй байна.

1.2. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖЭЭ.

1.2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, 0.5 сая төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах зардалд 76.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 75.9 сая төгрөг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 0.5 сая төгрөгийг СЕХ-ны 100900022001 тоот дансанд төвлөрүүлжээ.

Харин УБЕГ-ын даргын 2025 оны А/82 тоот тушаалаар аймгийн Улсын бүртгэлийн газарт 5.1 сая төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу бүрэн зарцуулжээ.

1.2.2. Аймаг, сумдын сонгуулийн хороо батлагдсан төсвийн дагуу зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнажээ.

Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралтын дагуу сумын сонгуулийн хорооны зардлын тайланг хянан хүлээн авч, аймгийн сонгуулийн хороо нэгтгэн тайлагнасан байна.

Сонгуулийн нийт зардлын гүйцэтгэлийн 68.7 хувь нь сонгуулийн хороодын гишүүд, мэдээлэл технологийн багийн гишүүдийн урамшуулал, хоолны зардал, 8.3 хувь нь саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх зардал, 4.3 хувь нь унааны зардал, 3.7 хувь нь сурталчилгааны зардал, 3.4 хувь нь шуурхай багийн зардал, 2.9 хувь нь томилолтын зардал, 1.9 хувь нь сургалтын зардал, 1.4 хувь нь бичиг хэрэг, 1.9 хувь нь шуудан холбоо, 1.6 хувь нь санал авах байр тохижуулах зардал эзэлж байгаа бол бусад зардал 1.9 хувийг байна.

Аудитаар аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлын тайланг дансны хуулга, анхан шатны баримттай тулган шалгахад ажил, гүйлгээ тус бүрийн баримтыг хангалттай бүрдүүлж, зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнажээ.

Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс сонгуулийн зардлын тайланг хугацаанд нь дээд шатны байгууллагад тайлагнасан байв.

1.2.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажилласан байна

Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10¹-т заасны дагуу аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны төсвийн хуваарилалтыг зардлын нэр төрөл бүрээр хүргүүлж, сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавьж ажиллажээ.

Мөн аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон сумын төрийн сангийн мэргэжилтэн аймаг, сумын сонгуулийн хорооны анхан шатны баримтад үндэслэн сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймаг, сумын сонгуулийн зардлыг СЕХ-оос өгсөн заавар, чиглэлийн дагуу тооцож, хуваарилж, зарцуулжээ төсвийн хуваарийн дагуу зарцуулжээ.
2. Аймаг, сумын сонгуулийн хороо нь “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу зардлын тайланг үнэн зөв, бодитой тайлагнасан байна.

¹ Сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина.